



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 411

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийт 3,659,622,400.00 (гурван тэрбум зургаан зуун тавин есөн сая зургаан зуун хорин хоёр мянга дөрвөн зуун) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Сүхбаатар аймгийн өмчид (Цагдаагийн газар) бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд, Сүхбаатар аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ө.Тайвансанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авч хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Барилгын доорх газар эзэмших эрхийг баталгаажуулах ажлыг зохион байгуулж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн
411... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХАРЬЯА СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАРТ БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, байршил		Тодорхойлолт	Нийт дүн (төгрөг)
1	Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын барилга, байгууламж (Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 2 дугаар баг)	Каракасан барилга	Тэнхлэгээрээ 12м х 30м, 12м х 12м хэмжээтэй, зоорьтой, 3 давхар, цутгамал төмөр бетон үндсэн хийцтэй, бүрэн хийц	2,715,673,951.0
		Гадна зам талбай, тусгай зориулалтын явган зам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний явган зам	11,450,880.0
			Жагсаалын талбай, явган зам 475м2	
		Гадна дулаан, цэвэр, бохир ус	Дулааны шугам-425м 1хос шугам, Цэвэр ус-425м	815,388,263.0
			Бохир ус-16м, 10м3 цооногтой	
		Дээвэр	504м2	54,719,306.0
Цахилгааны кабель утас	Гадна цахилгааны 0.4кв 3*185+120мм2 250м хос кабель	62,390,000.0		
	Нийт дүн			3,659,622,400.0